

МОНГОЛ ШҮЛГИЙН ТОЛГОЙ ХОЛБОХ АРГА, ТҮҮНИЙ ЗҮЙ ТОГТОЛ

Г.Галбаяр

Түлхүүр үгс: Холбоц, толгой холбоц, зүй тогтол, монгол шүлэг, үе, өргөлт

УДИРТГАЛ

Шүлгийн бүтэц тогтолцоог бүрдүүлэх олон зүйлийн нэг нь холбоц юм. Холбоцыг шүлгийн онолын сэтгэлгээний үүднээс, “Шүлгийн бадгийг холбон нэгтгэхийн зэрэгцээ түүний зааг ялгаврыг тогтоож өгдөг нь холбоц юм.” [Цэдэв Д. 1974:108] “Хоёр үгийг ямар нэг шинжээр нь (дуудлага, хэлбэр, утга гэх мэт) хооронд нь ижилсүүлэн холбохыг холбоц гэж томъёолдог. Холбоц өргөн утгатай ухагдахуун. ... Шүлгийн хувьд холбоц үүсгэж байгаа үгс дуудахад үүсэх үе, өргөлт нь ижил болж шүлгийн тогтолцоонд нөлөөлдөг зүйл. Холбоц үүсгэсэн үгс үе, өргөлтийн хувьд ижил болсноор тэрхүү холбоцын өмнөх юмуу дараагийн үгс холбоцод захирагдах зарчимтай. Иймд холбоцоор холбогдсон шүлгийн мөрүүд тогтолцооны хувьд ижил юмуу ойролцоо болох магадлалтай. [Morner, Kathleen. 1998:188-189] “Хоёр буюу хэд хэдэн шадьг ижил буюу төсөөт авиануудыг ижилсүүлэн эрэмбэ дараалалд оруулж холбох янз бүрийн аргуудыг бүхэлд нь холбоц гэнэ.” Галбаатар Д. 2012:519] гэх зэргээр тайлбарласан байна. Холбоц нь бадгийн мөрүүдийг холбон зангидах төдийгүй шүлгийн гол санааг илэрхийлэх үгсийг нэг утгад ижилсүүлэн нэгтгэж журмалдаг зүйл. Энэ үүднээс нь “шүлгийн бадгийн бүтцийг бий болгоход оролцож буй авианы давталтыг холбоц гэнэ” [Жирмунский В. 1923:9] гэж томъёолжээ. Шүлгийн холбоцын тухай өгүүлсэн дээрх томъёоллууд хийгээд энэ сэдвийн хүрээнд уншиж судалсан бусад судалгааг нэгтгэж үзвэл үгсийг холбож шүлгийн мөрүүдийг бүтээхдээ аль нэг газар нь ижил төсөөт үе, үгсээр тусгайлан холбож, тэрхүү холбоцод бусад үгсийг захируулан шүлгийн үе, өргөлтийг тааруулдаг байна. Иймд холбоц гэдэг нь шүлгийн мөрүүдийг холбох уран сайхны өвөрмөц арга аж. Өөрөөр хэлбэл шүлэгт тухайн хэлний авианы ижилсэл, эсрэгцэл зэрэг олон боломж нөөцийг уран сайхны дүрслэлийн аргын үүднээс ашиглан шүлгийн мөрүүдийг тодорхой хэсгүүдэд нь холбон зангидаж, нэгээс нөгөө нь ургаж, ургасан түүндээ ургуулж гаргасан нь эргээд захирагдах өвөрмөц тогтолцоо бий болгосон гэсэн үг. Үе, үгийг давтан хэлж хүч оруулах зарчмаас шүлгийн холбоц үүссэн гэж үзэх үндэслэлтэй. Тэгвэл холбоц нь шүлгийн мөрүүдийг бат бөх нэгтгэн зангидах үндсэн үүрэгтэй ажээ. Холбоцод эгшиг чухал үүрэгтэй. Эгшиг дангаараа төдийгүй гийгүүлэгчийг амилуулж холбоц үүсгэнэ. Шүлгийн холбоцын үед гийгүүлэгч ихэвчлэн ижил эгшгээр амилдаг онцлогтой аж. Монгол хэл эгшиг зохицох журамтай тул монгол шүлэгт эгшиглэнт шинж давамгайлдаг байна.

Хүн төрөлхтний шүлэгт толгой холбоц, дунд холбоц, хөл холбоц гэсэн үндсэн гурван холбоц зонхилдог байна. Хэлний онцлогоос нь хамаарч зарим газар дотоод холбоц, чөлөөт холбоц зэрэг өөр янз бүрийн холбоц ч бий аж. Тухайн улсын хэлний онцлог, шүлгийн зүй тогтлоос хамаарч холбоцууд янз бүрийн байрлалтай байдаг байна. Зарим улсын шүлэгт зөвхөн толгой холбоц буй бол зарим орны шүлэгт ганц хөл холбоц байх аж. Харин зарим улсын шүлэгт аль нэг холбоц нь давамгайлах шинжтэй, нөгөө бусад холбоцууд нь дагалдах шинжтэй ч орших нь бий. Монгол шүлэгт толгой холбоц тэргүүлэх үүрэгтэй, хөл холбоц, дунд холбоц бичсэн дарааллын дагуу дагалдах шинжтэй оршдог байна. Шүлгийн толгой, дунд, хөл холбоц бол шүлгийн мөрийн эхлэл, дунд, төгсгөлийг ялгаж, улмаар дараагийн мөрүүдтэй ижилсгэн холбож, шүлгийн бадгийг үүсгэдэг зүйл. Иймд шүлгийн холбоцууд шүлгийн тогтолцоог боловсронгуй болгоход чухлаар нөлөөлөхийн зэрэгцээ шүлгийн сонголт шинжийг эрс нэмэгдүүлдэг зүйл ажээ.

Холбоцууд гадаад хэлбэрийн талаасаа олон янз байх ч хамгийн түгээмэл нь:

- Тууш холбоц (AAAA)
- Зэрэгцсэн холбоц (AABB)
- Салаавчилсан холбоц (ABAB)
- Хаших холбоц (ABBA) байдаг байна.

Тууш холбоц:

Шүлгийн толгойг нэг ижил үе, үгээр туушид нь холбосон холбоцыг тууш холбоц гэнэ. Аливаа зүйлийг эхлэсэн янзаараа үргэлжлүүлэн зорьсон үр дүндээ хүрэх тууштай сэтгэлгээний илэрхийлэл болох энэ холбоц өөрөө өөрийгөө давтах маягаар үүснэ. Учир нь холбоцын эхлэл өөртэйгөө хамгийн ойр хэлэгдэх, сонсогдох авиа, үе, үгийг сонгох нь мэдээж хэрэг. Өөртэй нь хамгийн ойр буюу бүр ижил давтагдах авиа, үе, үг нь өөрөө байх тул тууш холбоцоор холбосон үед холбогдож байгаа мөрүүдийн дундуур өөр холбоц орох боломжгүй байдаг байна. Энэ нь монгол шүлгийн холбоц, тэр дундаа толгой холбоцод тууш холбоц тэргүүлэх үүрэгтэйг илэрхийлж буй хэрэг.

Зэрэгцсэн холбоц:

Шүлгийн толгойг хэд хэдэн ижил үе, үгээр зэрэгцүүлэн холбосон холбоцыг зэрэгцсэн холбоц гэнэ. Монгол хүн аливаа зүйлийг хооронд нь харьцуулан жишиж дундаас нь мөн чанарыг нь ухаардаг сэтгэлгээтэй тул энэхүү харьцуулан зэрэгцүүлсэн сэтгэлгээний илэрхийлэл болох зэрэгцсэн холбоц нь өөртэйгөө хамгийн ойр хэлэгдэж, сонсогдох авиа, үе, үгээр ижилсэн зэрэгцэж оршино.

Салаавчилсан холбоц:

Шүлгийн мөрүүдийн толгойг алгасан ижил үе, үгээр салаавчлуулан хооронд нь холбосон холбоцыг салаавчилсан холбоц гэнэ. Энэ холбоц монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авиануудын хоорондоо сэлгэх сэлгээний зүй тогтолд суурилж үүсэн тул монгол шүлэгт ийм холбоц түгээмэл буй.

Хаших холбоц:

Шүлгийн захын хоёр мөрийн толгойг, дундах мөрүүдийн толгойг тус тусад нь ижилсүүлэн холбосон холбоцыг хаших холбоц гэнэ. Ямар нэг эрхэм нандин зүйлсээ хамгаалж, хаших сэтгэлгээний үүднээс үүссэн энэ холбоц монгол шүлэгт цөөнгүй байна.

Шүлэгт холбоц үүсч, улмаар хэмнэл үүссэнээр шүлгийн үндсэн шинж бий болно. Өөрөөр хэлбэл холбоц, хэм хэмнэл тэргүүтэн нь шүлгийг үргэлжилсэн үгийн зохиолоос ялгадаг гэж хэлж болно. Тийм ч учраас судлаач Ц.Дамдинсүрэн “Шүлэг бол үргэлжилсэн үгийн зохиолоос мөрийн хэмжээ, холбоц хоёроор ялгарна” [Дамдинсүрэн Ц. 1938:191] гэж бичжээ. Хэлний авиаг шүлгийн хэлэнд ижилсүүлэх, эсрэгцүүлэх зэргээр тодорхой байрлалд оруулан ашиглаж уг шүлгийн уран сайхан чанар, бүтэц тогтолцоог бүрдүүлдэг билээ. Учир

нь “шүлгийн холбоц ижил хийгээд ойролцоо эсвэл бүр эсрэг авиануудыг тодорхой журмаар давтан хэрэглэх зарчимд суурилдаг байна.” [Wesling, Donald 1980:41] Энэ нь холбоц шүлгийн тогтолцооны чухал зүйлийн нэг болохыг харуулж байгаа хэрэг. Монгол шүлгийн толгой холбоц ямар онцлогтойг энэ удаа авч үзсэн болно.

I. ШҮЛГИЙН ТОЛГОЙ ХОЛБОХ ЁС БА МОНГОЛ ШҮЛГИЙН ТОЛГОЙ ХОЛБОХ АРГЫГ СУДАЛСАН НЬ

Шүлгийн толгой холбоцыг “ALLITERATION”, “АЛЛИТЕРАЦИ” гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Зарим улсад эртний грек хэлний “АНАФОРА” буюу “ТОЛГОЙ ИЖИЛ” гэсэн утга бүхий үгээр ухаарах нь бий. “Alliteration” хэмээх үг нь латин хэлний *ad+littera* буюу “ойролцоо үсэг, нөхөр үсэг” гэсэн утгатай үг. Бидний санавал “alliteration” гэсэн үгтэй монгол шүлгийн толгой холбоцыг яг дүйлгэн ойлгох нь тодорхой хэмжээнд учир дутагдалтай. Учир нь өрнө дахины эртний шүлэгт байсан мөрийн эхний холбоцыг заах энэ үгний илэрхийлэх утгаас монгол шүлгийн толгой холбоц нэлээд өөр буюу монгол үндэстний аж амьдрал, соёл, сэтгэлгээний олон зуун жилийн онцлог буюу аливаа зүйлийн эхлэлийг “*гараа сайн бол бариа сайн*” гэх мэтээр онцгой анхаарч сайнаар эхлүүлдэг ёс уламжлалтай нарийн сэжмээр холбоотой ойлголт юм. Өрнөдийн шүлэг-яруу найргийн онол, нэр томъёог дагнан судласан судлаач Л.Квятковский “Яруу найргийн толь” бүтээлдээ “Аллитераци шүлгийн эртний хувилбар Европ, Азийн зарим үндэстний (герман, швед, казак, киргиз, буриад болон бусад) яруу найрагт байна” [Квятковский Л.1983:46] гэж бичсэн байна. Мөн өрнөдийн шүлгийг судласан судлаач В.Жирмунский “Шүлгийн онол” бүтээлдээ “Эртний германы аллитераци шүлэг” гэсэн тусгай бүлэг оруулж, энэ тооллын 700-1100 оны хооронд англосаксон, эртний исланд, эртний саксон, эртний германы толгой холбоцын шүлэг нь хөгжлийнхөө явцад аажмаар шүлгийн адаг холбоц буюу хөл холбоцод ууссан болохыг тодорхой баримтад тулгуурлан өгүүлжээ. [Жирмунский В. 1975:376-380] Тэрбээр мөн германы баатарлаг туульс ихэвчлэн аллитераци хэлбэртэй байсан онцлогтойг өгүүлээд “Эн зэрэгцүүлэл гэж нэрлэгддэг хоёр ойр төрлийн ойлголт ерөнхий нэг холбоосоор зангилагдаж хэл зүйн зэргэд үүсгэдэг” [Жирмунский В. 1975:381] хэмээн онцлон өгүүлсэн байна. Эртний монголчуудын өвөг болох Хүннүчүүдийн өрнө рүү хийсэн аян дайн, тэд эзэлж авсан газрууддаа тархан суурьшсанаар монгол шүлгийн толгой холбох ёс ямар нэгэн хэмжээгээр эртний аари үндэстэн, фин-угорын бүлгийн улсууд, скандинавын орнуудын шүлэг найрагт нөлөөлсөн бололтой. Энэ асуудлыг тусгайлан судлууштай зүйл тул энд эс өгүүллээ.

Шүлгийн толгой холбоц хэмээх ойлголтыг шүлгийн онолын бүтээлүүдэд, “Толгой холбоц гэдэг нь шүлгийн мөрийн эхний авиаг ижилсүүлэхийг хэлнэ. ... Толгой холболт тодорхой тоогоор нэгдсэн айзамт мөрүүдийг аялгуулан зааглах үүрэгтэй.” [Цэрэнсодном Д. 1977:87, 88], “Толгой холболтыг шүлэглэсэн болоод үргэлжилсэн үгийн зохиолын аль алинд нь хамаатуулж ойлгох боломжтой ч шүлэглэсэн зохиолд илүү хамааралтай зүйл. Эртний Англи, Герман зэрэг улсын яруу найрагт толгой холболт хэмээх ойлголт байжээ. Шүлгийн эхний авиа, үеийг чухалчлан үзэж хооронд нь ижилсүүлэн холбож, шүлгийн сонсголонт шинжийг нэмэгдүүлдэг зүйл” [Morner, Kathleen. 1998:5], “Шүлгийн шадын эхний үсэг, үе, үг, холбоо үгийг доош шад дараалуулан давтаж бичих холбоцыг толгой давталт гэнэ” [Галбаатар Д. 2012:350] хэмээн бичсэн байна. Энэ бүхнийг нэгтгэж үзвэл шүлгийн шадын эхний авиа, үе, үг, холбоо, хоршоог бичлэг, дуудлагын ижил төсөөтэй шинж, тэрчлэн эсрэгцэн харшиж нэгдэх онцлог зэргээр нь ижилсүүлэн холбох аргыг шүлгийн толгой холбоц гэдэг байна. Монгол шүлгийн тогтолцоог бүрдүүлэх олон хүчин зүйлийн нэг нь холбоц, тэр дундаа толгой холбоц юм. Холбоц өнгөн талдаа шүлгийн хэлбэрийг төгөлдөржүүлэх мэт боловч дотоод мөн чанартаа туурвиж байгаа үндэстнийхээ хэл, сэтгэлгээтэй нарийн сэжмээр холбогддог зүйл. Шүлэг туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний уугуул хэв загварыг илэрхийлдэг тул монгол шүлгийн

толгой холбох ёс нь монгол хүний аливаа зүйлийн эхлэлийг эрхэмлэн чухалчилж үздэг үзэлд суурилдаг байна. Шүлгийн мөрүүдийн эхлэлийг ижил, ойролцоо, эсрэг дуудлага, утгатай үе, үгээр холбож шүлгийн толгой холбоцыг хийдэг байна. Ингэж шүлгийн мөрүүдийн эхлэл хэсэг тодорхой зүй тогтолд орж холбогдсоноор шүлгийн мөрүүд бие биеэндээ ижилсэн уусаж, тэр хэмжээгээрээ адилхан хэмнэл үүсгэдэг байна. Адил хэмнэлд орсноор шүлгийн мөрүүд хоорондоо үе, өргөлтийн хувьд мөн адил болж жигдэрдэг ажээ.

Монголын аль ч цаг үеийн аман хийгээд бичгийн уран зохиол дахь шүлгийг авч үзэхэд ихэнх нь толгой холбогдож бичигдсэн байна. Тиймд монгол шүлгийн толгой холбох ёсны тухай монгол шүлгийг судласан дотоод, гадаадын цөөнгүй судлаач анхаарлаа хандуулсан билээ. Монгол шүлэг судлалын түүхээс харахад эртний Энэтхэг, Түвдийн шүлэг-яруу найраг тэр дундаа эртний Энэтхэгийн шүлэг-яруу найргийн онолч Дандины “Зохиост аялгуун толь”-ийн хүрээ хамааралд монгол шүлгийг судласан эрдэмтэн мэргэдийн судалгаанд монгол шүлгийн толгой холбоцын тухай онцлон өгүүлсэн зүйл төдийлөн таарахгүй байна. Энэ нь Энэтхэг, Түвдийн шүлэгт толгой холбоцын тухай ойлголт байдаггүйтэй холбоотой биз. Монгол шүлгийн толгой холбоцын тухай одоогийн байдлаар бидэнд мэдэгдэж байгаа хамгийн эртний баримт бол 1740 онд туурвигдсан “Мэргэд гарахын орон” хэмээх бүтээл юм. Тэрхүү бүтээлд “монгол хэл дор алдаршсан толгой холбох мэт ...” [Мэргэд гарахын орон. 1740:23] хэмээн монгол шүлэгт толгой холбоц чухал үүрэгтэй тухай онцлон өгүүлсэн байна. Тэгвэл XIX зууны монголын нэрт яруу найрагч В.Гүначуг “Иргэн үсэг дор фин (-тэгш) шан (-өсгөх) чүй (-долгио) лүе (-уруудах) буй хэмээхэд монгол үсэг дор мөн эр эм саармаг үсгийн ялгал буй болой. Иргэн дор шүлэг аялгуу байхад монголд мөн ч аялгуу буй. Адилтгаваас аль үсгээр тэргүүнийг эхэлсэн бол төгсгөлд тэр үсгээр эхэлбээс даруй аялгуу нийлэлцэх болой. Хэрэв “А” толгойгоор эхэлбээс “Ариун ..., Агуулан ..., Амттай ..., Архи ...” хэмээх мэтээр даруй аялгууны шүлэг болох болой” [Гүначуг В. 1959:32] гэж бичсэн нь монгол шүлэгт хөг аялгуу чухал үүрэгтэйг илэрхийлсэн ч угтаа бол монгол шүлэг толгой холболтоор бичигддэг онцлогтойг тодотгосон хэрэг юм. Түүний энэ саналыг төрсөн дүү В.Инжаннаши нь дэмжиж “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” романыхаа өмнөх “Товчит толь”-доо “Улс улсын зан суртлын аяыг дагаж улс улсын бичиг судар ч их аяс зан санаа нь өөр өөр. Үлгэрлэвэл ертөнцийн уур амьсгал туйлын сайхан өнгөт нь цэцэг атал цэцэг бүр адилгүй өөр өөртөө нэг зүйлийн сайхан өнгө буй. Бас ертөнцийн уур амьсгалын туйлын амттайхан амт нь жимс бөгөөд жимс бүр адилгүй тус тусдаа нэгэн зүйлийн амттайхан амт бус уу. Үзтэл иргэн үсг сүүл даран хэлж, монгол үг толгой холбон өгүүлэх, төвд үсэг түргэн төдийг эрхэлж, манж үсэг тус тааруулан зохиочихуй” [Инжаннаши В. 1959:58] гэж монгол шүлгийн хамгийн гол онцлог нь толгой холбох зарчимдаа байдгийг чухалчлан өгүүлжээ.

Монгол шүлгийг XIX зууны дунд үеэс өрнөдийн монгол судлаачид судлаж эхэлсэн түүхтэй. Тэд ч монгол шүлгийн онцлог толгой холбоцонд нь байгааг ажиглаж онцлон өгүүлсээр иржээ. Тухайлбал, Оросын монгол судлаач А.Позднеев “монгол шүлгийн гол онцлог толгой холбох явдал” [Позднеев А. 1880:324], Оросын монгол судлаач Н.Поппе монгол туулийн шүлэглэлийн онцлогийг судалж үзээд “монгол туулийн бадагт толгой холбосон аллитерацаас гадна дотоод аллитераци ч зарим үед харагдаж байна” [Поппе Н. 1937:116], Чехийн монгол судлаач П. Поуха “Монгол шүлгийн гадаад гол шинж нь гэвэл толгой холбож ая нийлүүлэх явдал юм. Ийм шинж монгол шүлэглэлд эрт дээр үеэс тодорчээ. ... Толгой холбоц зонхилсон “Монголын нууц товчоо”-ны шүлэглэсэн зарим хэсгийг үзвээс толгой холболт нь зөвхөн шүлгийн мөрний эхэнд чухам ямар авиа байгаагаас шалтгаалаад зогсохгүй харин шүлгийн эхний нэгдүгээр үеэнд ямар авианы нийлбэр байгаагаас голчлон шалтгаалж байна” [Поуха П. 1968:19,26] гэж үзэцгээжээ.

Орчин үеийн шүлэг судлалын онол, арга зүйн үүднээс монгол шүлгийг судласан манай судлаачид ч монгол шүлгийн гол онцлог толгой холбоцдоо байгаа тухай өгүүлжээ. С.Буяннэмэх “Холбоо найруулга гэж толгой холбосноос нэрлэжээ. Энэ нь А бол А, Э

бол Э толгой үсгийг олж мөрүүдийн дээд тэргүүнийг нь тохируулах бөгөөд тийнхүү тохируулахдаа шүлгийн адил заавал дөрөв дөрвөөр толгой холбож нэг нэгэн бадгаар бичих ёстой юм. Хичнээн толгой, хичнээн мөр боловч хязгаарлагдахгүй ба бадаг хэмээн холбоо найруулгат зориуд ялгаварлах явдалгүй ажгуу” [Буяннэмэх С. 1935:111-112], Н.Жамбалсүрэн “Монгол шүлгийн толгой холбох нь европ шүлгийн сүүл холбоотой адилхан юм. Толгой холбохдоо ойролцоо дуудлагатай үгээр холбож болно. Толгой холбохдоо баялаг үгтэйгээр чадамгай холбож хэрэглэвэл шүлгийг сайхан болгоно” [Жамбалсүрэн Н. 1966:3], Л. Түдэв “Монгол шүлэг гэж хармагц эсвэл сонсмогц таних тэмдэг нь “толгой холбоц” юм” [Түдэв Л. 2002:389] гэж бичсэн байна.

Монгол шүлгийг судласан дотоод, гадаадын цөөнгүй судлаачид монгол шүлгийн гол онцлогийн нэг нь толгой холбоц гэж бичсэн ч учир шалтгаан, мөн чанарыг нь нарийвчлан өгүүлсэнгүй. Тиймд энэ удаад бид монгол шүлгийн толгой холбоцын учир шалтгаан, зүй тогтлыг тодруулахыг хичээж байна.

II. МОНГОЛ ШҮЛГИЙН ТОЛГОЙ ХОЛБОХ АРГА, ТҮҮНИЙ ЗҮЙ ТОГТОЛ

Монгол аман зохиол хийгээд “Монголын Нууц Товчоо” тэргүүтэй эрт, эдүгээгийн шүлэг-яруу найрагт толгой холбох ёс зонхилох шинжтэй нь тодорхой билээ. Энэ нь “Шүлгийн байгуулалтыг тодотгох элдэв холболтоос монгол шүлэгт толгой холболт маш их үүргийг гүйцэтгэдэг” [Цэнд Д. 1979:161] болохыг баталж байгаа хэрэг.

Монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж нь хоёр мөрт шүлэг буюу хос уянга. Жишээлбэл аман зохиолд,

Зүйргүй үг байдаггүй

Зүйдэлгүй дээл байдаггүй

* * *

Ганц мод гал болдоггүй

Ганц хүн айл болдоггүй

* * *

Олон үгэнд олзгүй

Ганц үгэнд гарзгүй Цэрэнсодном Д. 2012:53,59]

Мөн “Монголын Нууц Товчоо” бүтээлийн,

76 дугаар зүйлд,

Se'üder-ece busu nökör ügei

Se'ül-ece busu cicu'a ügei

79 дүгээр зүйлд,

Qoluqat qo'ojju'u

Silüget siberijü'ü

96 дугаар зүйлд,

Bököre-yin bökse-tür

Cekere-yin ce'ejü-tür

[Rachewiltz Igor De. 1972:29,30,37] гэх мэтээр өгүүлжээ. Энэ мэт жишээ баримтыг монголын аман хийгээд бичгийн шүлэг-яруу найргаас хэдэн зуу, мянгаар нь харж болно. Хос мөрийн толгойг холбож шүлэглэх энэ аргын учир шалтгааныг судлаач Б.Ринчен “Холбоцын хувьд хоёр хоёр шадаар толгойгий нь холбох зүйл монгол шүлэгт үлэмж үзэгдэх бөгөөд аман

зохиолд зогсоогоор бэлэн холбох үгэнд үлэмж хэрэглэдэг нь уг шүлгийг дор нь зохиодог байдалд хошоод хошоодоор холбох нь дөхөмтэйн учраас эл зэрэгцсэн холбоц их хэрэглэдэг байна” [Ринчен Б. 1970:28] гэж тайлбарлажээ.

Монгол хүний аливаа зүйлийг өөр бусад ямар нэг зүйлтэй харьцуулан жишиж дундаас нь мөн чанарыг нь ухаж ойлгох сэтгэлгээтэй холбоотойгоор хос уянгын аль нэг мөрд (ихэвчлэн эхний мөр) ертөнцийн мөн чанарын тухай бичих бол нөгөөд нь хүний амьдралын утга учрын тухай бичдэг тул харьцуулан жишиж буй хоёр зүйлийг шүлэглэхдээ толгой холбоцын аргаар (хөл холбоц, дунд холбоц ч түгээмэл бий) ижилсүүлэн холбож нэг цогц утгыг илэрхийлдэг байна. Тиймд шүлгийн холбоцууд тэр дундаа толгой холбоц шүлгийн утга санааг зангидаж нэгтгэх, мөрүүдийн хэм хэмжээг тааруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Дээрх жишээ болоод бусад зүйр цэцэн үгээс ажиглавал толгой холбоцыг ижил үе, үгээр, ойролцоо дуудлагатай үе, үгээр, эсвэл бүр эсрэг утгатай үе, үгээр холбож болдог нь тодорхой харагдаж байна.

Монгол шүлэгт хос уянгыг нэг цогц утгад зангидан дахин ижил хос уянгатай ижилсүүлэн өрөх маягаар дөрвөн мөр шүлгийг үүсгэдэг зарчимтай. Ийм шүлгийн сонгодог жишээ бол ардын дуунууд юм. Дуу бол хүний сэтгэлийн хайлал, ухааны урлал. “Үгээ хөгжүүлэн урт богиноор нь янз бүрийн хувилбарт оруулснаар шүлэг зохиолтой болсон хэрэг. Дуу авиагаа өндөр намаар нь найруулан журамласаар дуулах дуутай болсон хэрэг. Дуу, шүлэг хоёр ийнхүү ихэр төрсөн ах дүүс. Тиймээс дууны яруу найраг хэл яриа шиг л өндөр настай.” [Түдэв Л. 2002:348-349] Монголчууд сэтгэлийн үг, ухааны урлалаа дуундаа шингээсэн байх тул монгол дуу монгол шүлгийн тогтолцоог бүрэн дүүрэн харуулж чадах зүйл. Нүүдлийн соёл иргэншлээр амьдарч ирсэний хувьд монголчуудын мал аж ахуйн сэдэвтэй дуунууд нэн эртний улбаатай, тэр хэмжээгээрээ өдгөө үнэ цэнэтэй. Тухайлбал, хөдөлмөрийн дуу “Тойг”-т,

Хундан цагаан хонь минь

Хургаа юундаа голоо вэ

Сүүний чинь үнэр

Сүүлэнд нь байна шүү дээ [Цэрэнсодном Д. 2012:206] хэмээн шүлэглэхдээ хоёр хоёр мөрөөр нь зэрэгцүүлэн толгой холбожээ. “Хурдан” гэх үгийн оронд “Халзан” гэж оруулбал адилхан л “Х” авиагаар толгой холбож болох мэт харагдах ч “Хурга” гэдэг үгтэй илүү бат бөх холбох үүднээс “Хундан” гэх үгийг сонгон оруулсан нь шүлгийн толгой холболтыг монгол шүлэгт үе болоод үгээр хийдэг зарчимтайг харуулж байна. Энэ нь тухайн холбоц илүү бат бөх болж, тэр хэмжээгээрээ яруу сонсголонт шинжтэй болдог байна. Ийм учраас сүүлийн хоёр мөрийг нь “Сүү” гэсэн үеэр холбож шүлэглэжээ. Тэгвэл домог түүхийг нь үзвэл нэлээд жожуу бичигдсэн байх “Эрдэнэ засгийн унага” дуунд,

Эрдэнэ засгийн унага нь

Эрэмгий болоод жороо доо

Элсэн манхан нутагтай

Эмгэн буурал ээжтэй дээ гэсэн шүлгийн дөрвөн мөрийг бүгдийг “Э” эгшиг авиагаар тууш холбосон мэт өнгөн талдаа харагдах ч нэг цогц утга илэрхийлэх эхний хоёр мөрийг “Эр” гэсэн үеэр, дараагийн хоёр үеийг “Элсэн, Эмгэн” гэсэн дуудагдах аялгуу ойролцоо үгээр бүтнээр нь холбожээ. Энэ нь монгол шүлгийн толгой холбох зарчим ямар ч үед өөрчлөгдөлгүй тогтвортой бат бөх байж ирснийг давхар харуулна. Түүгээр ч барахгүй уг шүлгийн эхний хоёр мөр нэг цогц утга, дараагийн хоёр мөр нэг цогц утга илэрхийлэх ч бүгд толгой холбох нэг аргаар холбогдон нэгдсэн нэг утга илэрхийлэх бол тус шүлгийн нэг, гуравдугаар мөр, хоёр, дөрөвдүгээр мөр нь хөлөөрөө салаавчлагдан давхар холбогдож тус шүлгийн тогтолцоог илүү цул бат бөх болгож байна. Энэ арга бол монгол шүлгийн холболтын, улмаар тогтолцооны маш чухал зүй тогтол юм. Уншигч судлаачдын дунд хүлээн

зөвшөөрөгдсөн ихэнх шүлэг холболтын ийм аргаар туурвигдсан байдаг. Энэ нь монгол шүлгийн хувьд холбоцууд тухайн шүлгийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдгийг харуулж байгаа хэрэг. Тэгвэл, “Алтан богдын шил” хэмээх монгол ардын уртын дуунд,

Алтан богдын шилд нь

Алтан гургалдай жиргэнэ

Алтан гургалдайн дуунд нь

Агт морь сульдана [Цэрэнсодном Д. 2012:252] гэж шүлэглэсэн бол “Аргагүй амраг” хэмээх ардын богино дуунд,

Нуураа чи хөлдөх гээд байна уу даа

Нугас гэдэг амьтан чинь хөөрхий болно доо

Нууцгай чиг ханилсан чи бидэн хоёр

Арга ч үгүй амраг юм уу даа [Цэрэнсодном Д. 2012:274] гэж өгүүлжээ. Дээрх хоёр дууны шүлгийн толгойг тууш холболтоор гүн бат холбосон бол хөлийг дээр өгүүлсний адилаар салаавчлан холбож шүлгийн бүтцийг гүн бат тогтолцоотой болгожээ. Харин шүлгийн утгын өргөлтийг хадгалсан гол мөрийн толгойг бусад мөрийн холбоцоос ялгаруулан сул, эсвэл холболгүй үлдээдэг онцлог монгол шүлэгт бас байна. Бусад мөрийн толгой холбоцоос ялгаруулан үлдээсэн энэ мөрийн толгой бусад мөртэйгөө холбогдоогүй үлдсэн мэт харагдах ч утгын өргөлтөөрөө бусад мөрүүдээ өөртөө татаж байна. Ингэж утгын өргөлтөөрөө бусад мөрөө захирах тул харин ч далд хэлбэрээр бусад мөрүүдийн толгой холбоцыг илүү нэгтгэн нягтруулж байна гэж үзэж болмоор байгаа юм. Гол утгаа илэрхийлсэн мөрийг нь өнгөн талд нь толгой холболгүй, харин далд цаана нь утгын өргөлтөөр нь бусад мөрийн толгой холболтыг зангидуулан илүү гүн бат холболт үүсгэдэг арга монголын эрт, эдүгээгийн бичгийн уран зохиолд ч түгээмэл буй. Жишээлбэл, “Монголын нууц товчоо” бүтээлийн 245 дугаар зүйлд,

Ne'üle metü beye cinu

Negüs odu'asu

Netkel metü ulus cinu

Ken-e mede'ülkün tede

Tulu metü beye cinu

Tulbas odu'asu

Tuyal metü ulus cinu

Ken-e mede'ülkün tede [Rachewiltz Igor De. 1972:142] хэмээн өнгөн талдаа дөрөвдүгээр мөрийн толгойг бусад мөртэй холбоогүй байна. Харин утгын өргөлтөөр нь бусад мөрийг нь энэ мөрөндөө захируулан илүү бат бөх холбоц үүсгэсэн нь тухайн шүлгийн урлалыг илүү нарийн уран болгожээ.

Хэц хэнгэргийн хэмнэлээр өгүүлэгдэх бөөгийн шүлэг холбоцын хувьд онцгой төгөлдөр аж. Учир нь хэнгэрэг хэцийн хэмнэл нь зорилго, зориулалт бүртээ өөрчлөгдөж, түүндээ бөө удганы хэлэх шүлэг таарах тул холбоцууд нь ижил болдог байна. Жишээ нь, Баглаан удганы дуудлага,

Асар тэнгэр хөмрөг минь

Аадрын үүл хөдрөг минь ... гэж эхлэхэд шүлгийн толгой, дунд, хөл хэсэг тус бүртээ ижилсэн холбогдсон байхад өөр нэгэн дуудлагад,

Нарийн могой минаа минь

Бүдүүн могой унаа минь ... хэмээн шүлэглэхэд “Нарийн, Бүдүүн” гэсэн эсрэг утгат үгсээр шүлгийн толгойг утгачлан холбосон нь тухайн шүлгийг уран яруу болоход

зохих нөлөөг үзүүлсэн нь илхэн байна. Энэ мэтээр шүлгийн толгойг холбосноор энэхүү холбоц мөрүүдийнхээ дараа дараагийн холбоцыг үүсгэх төдийгүй мөр бүрийн үгийн өргөлт, үеийн тоог таарахад ч зохих нөлөөг үзүүлдэг болох нь харагдаж байна. Бөө мөргөлийн дуудлага, зүхэл, шахаа, даллага, үгүйлэл зэрэг аль ч төрөл зүйлийн шүлгийг толгой, хөл, дунд нь чанд холбодог нь тодорхой аж. Бөөгийн шүлэг нь бөөгийн өчсөн өчил, дуудсан дуудлага, зүхсэн зүхэл голдуу байдаг. Хэлсэн хэллэг, өчсөн өчил нь заавал биелэх онцгой шинжийг хадгалах тул шүлгийн төгсгөлд илүү ач холбогдол өгч утгын өргөлт өгөгдөх тул шүлгийн хөл холбоц илүү чанд холбогддог онцлогтой байна.

“Монголын Нууц Товчоо” зохиол бол монгол шүлгийн урлалын сонгодог жишээ болсон бүтээл. Тиймд уг зохиолоос цөөн хэдэн жишээ авч үзье. Тус зохиолын,

96 дугаар зүйлд,

Qara buluqan daqu-yin qari'u
Qaqacaqsan ulus-i cinu qamtutqaju öksü
Buluqan daqu-yin qari'u
Butaraqsan ulus-i cinu bügütke[l]düyü öksü

245 дугаар зүйлд,

Manaqaru ügüleksen-i
Üdesi hudaru'asu
Üde-yin ügüleksen-i

Manaqaru hudaru'asu [Rachewiltz Igor De. 1972:37,144] хэмээн шүлэглэсэн байна. Монгол шүлэгт холбоц, тэр дундаа толгой холбоц онцгой чухал үүрэгтэйг дээрх жишээ шүлгүүдээс харж болохоор байна. Эхний шүлгийн толгойг зэрэгцсэн холбоцоор, дараагийн шүлгийн толгойг хаших холбоцоор холбохдоо хөл холбоцыг давхар үүсгэжээ. Өгүүлэн буй хоёр шүлэгт адилхан нэгдүгээр мөрийг гуравдугаар мөртэй, хоёрдугаар мөрийг дөрөвдүгээр мөртэй хөл холбоцоор салаавчлан холбож, өргөлттэй, өргөлтгүй үгийн тоо, түүгээр ч үл барам үеийн тоог салаавчлуулан тэгшитгэжээ. Ингэснээр уг шүлгүүдийн хэм хэмнэл таарч, яруу сонсголонт шинж нь нэмэгдсэн байна. Энэ өвөрмөц нарийн тогтолцоогоо дагаад шүлгийн утга санаа ч гүн гүнзгий болжээ. Монгол шүлгийн тогтолцоо өнгөн талаасаа тодорхой нэг янзаар харагдах ч гүндээ өнгөн талын тогтолцооноосоо ургасан чанд нарийн давхар тогтолцоо үүсгэж урладаг байна. Иймд монгол шүлгийн тогтолцоо бат бөх, бас тал бүрээс нь янз бүрээр тайлбарлаж болохоор байдаг аж. Шүлэг бол туурвисан үндэстнийхээ соёл сэтгэлгээний цөм хэв загварыг илэрхийлж туурвигддаг зүйл. Өөрөөр хэлбэл монгол шүлэг бол монгол хүний аливаа зүйлд хандахдаа байгаль цаг уур хийгээд нийгмийн элдэв таамаглашгүй гэнэтийн зүйлийг далд тооцоолдог хийгээд байгаль ертөнцийн гүн бат уран бүтцийг өргөн хүрээтэй ухаж мэдсэн мэдрэмжээс үүдэлтэй сэтгэлгээний илэрхийлэл аж. Монгол шүлэг холбоцууд хийгээд уран дүрслэлийн бусад олон аргын уран хослолоор урлагдах тул гадна талаас нь өнгөц харахад товч тодорхой тогтолцоотой мэт харагдах ч гүндээ нарийн төвөгтэй, тэр хэмжээгээрээ төгөлдөр бүтэц үүсгэдэг байна. Энэ бүхэн нь монгол шүлэг төгөлдөр бүтэц тогтолцоотой, уран яруу сонсголонт шинжтэй, утга гүн байдгийг тодорхой гэрчилж байна. Монгол шүлгийн утга санаа, бүтэц тогтолцоонд холбоцууд тэр дундаа толгой холбоц чухал үүрэгтэйг эндээс харж болох ажээ.

Тэгвэл “Монголын Нууц Товчоо” зохиолын,

137 дугаар зүйлд,

Bosoqa-yin cinu bo'ol boltuqai
Bosoqa-daca cinu bulji'asu
Borbi inu hoqtol

E'üten-nü cinu emcū bo'ol boltuqai

E'üten-nece cinu heyilü'esü

Eliget anu etkejü gētkün

200 дугаар зүйлд,

Qara keri'e qarambai noqosu bariqu bolba

Qaracu bo'ol qan-tur-ıyan qar gürgегü bolba

Qahan anda mini ya'u endegü

Boro quladu borcin sono bariqu bolba

Bo'ol nekün бүдүн ejen-ıyen bosoju (?) nendejü bariqu bolba

Boqda anda minu ya'u endegü [Rachewiltz Igor De. 1972:59,111] гэж шүлэглэсэн байна. Хүний сэтгэлээсээ өчиж хэлсэн чухал үгийг монгол шүлэгт сондгой тоотой мөрөөр бадагладаг онцлогтой. Сондгой тоотой мөрөөр бадаглах нь хэн нэгний хэлсэн хэл, захисан захиа, өчсөн өчил байх тул сондгойрсон мөрөөр бадгийг хааж, утгын өргөлтийг хийх тул энэ мөрийн толгой холбоц бусад мөрүүдийнхээ холбоцыг захирах шинжтэй болдог байна. Утгын өргөлт бүхий энэ гол мөрийг дөрвөн мөрт шүлэгт ч толгой холбоцоор нь ялгаруулан шүлэглэдэг тухай дээр өгүүлсэн билээ. Холбоцын энэ арга бол монгол шүлгийн өвөрмөц нэг онцлогийг илэрхийлж байна.

Монголын уран зохиолын томоохон дурсгал болох Лувсанданзаны “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиол товчлон хураасан алтан товч хэмээх оршвой” бүтээлийн шүлгүүд утга санаа, урлалын хувьд онцгой. Тус зохиолд

Atarq-a-tu ayula-yi abalam ta

Arıali uyuljin-i alam ta

Arıali uyulja-yin miqan-i qubilan qubiyaqui-ača ulam

Alaldun teskildün qayačam ta

Budang-tu [=budungtu] ayula-yi abalam ta

Bıyу soıyу alam ta

Bıyу-yin miq-a-yi qubilan qubiyaqui-ača ulam

Butaraldun teskildün qayačam ta ... хэмээн урнаар шүлэглэжээ. Мөн бас

Qutuy-tu [=qutuytu] törügsen boyda ejen-i [=ejen-ü] ene kesig-i

Qun yalayun metü dayun-ıyan nigedčü

Qula čiketei [=čiketei] metü jisüben [=jisü-ben] neyilejü

Qurayсан bügüde jirıyaldun čenggeyele [=čenggey-e le]

Ačitu törügsen qayan ejen-i =ejen-ü] ene kesig-i

Anggir yalayun metü dayun-ıyan nigedčü

Arıal-i [=arıali] maral metü jisüben [=jisü-ben] neyilejü

Amaray sayiqan nöküd-ıyen abun jirıayala [=jirıay-a la] [Лувсандандан.

2011:152,199] гэх зэргээр шүлэглэхдээ шүлгийн толгойг зэрэгцүүлэн холбожээ. Ингэж толгойг холбосноор мөр бүрийн үгийн тоо, өргөлттэй өргөлтгүй үеийн тоо харьцангуй жигдэрч нэгэн ижил хэмнэл үүсгэсэн байна. Энэ тогтолцоо дараа дараагийн олон бадгуудад огтхон ч өөрчлөгдөөгүй нь энэ зохиолыг бичих үед монгол шүлгийн толгой холбоцын энэ зарчим бүрэн төлөвшиж тогтсон байсныг гэрчилж байгаа хэрэг. Ардын аман зохиол хийгээд эртний бичгийн уран зохиол дахь шүлгийн толгой холболт нь ижил, ойролцоо юмуу эсрэгцсэн үе, үгээр голчлон холбогдож байна. Энэ нь монгол шүлгийн толгой холболт авиа үсгээр бус үе, үгээр

холбогддог журамтайг гэрчилнэ. Үе, үгээр толгой холбосноор тухайн шүлгийн холбоц гүн бат, тэр хэмжээгээрээ шүлгийн бүтэц тогтолцоо тогтвортой болдог байна.

Монголын уран зохиолын хөгжил XIX зуунд тодорхой хэмжээгээр шинэчлэгдсэн түүхтэй. Энэ үеийн уран зохиолд гарсан шинэчлэлийг олон жишээ баримтаас харж болох ч Д.Равжаагийн бүтээлүүдээр төлөөлүүлэн ойлгож болно. Д.Равжаа “Хурмаст тэнгэр” шүлэгтээ,

*Үүл нь гараад бороо орохын цагт
Үүдэн гэмээ нь хоймор юуны ялгаа вэ?
Үйл нь байгаад үхэхийн цагт
Хөгийн гэмээ нь залуу юуны ялгаа вэ? ..., “Ичиг ичиг” шүлэгтээ,
Аяа бас, буян хураасангүй насжисан хөгийнд ичиг
Аяа бас, сэтгэлээ зассангүй гангалагч залуучууд ичиг
Аяа бас, номыг сэтгэлтэйгээ нийлүүлсэнгүй мэргэд ичиг*

Аяа бас, албатаа алаглагч ноёд ичиг ... [Равжаа Д. 1992:85,287] гэх зэргээр шүлгийн толгойг нягт нарийн холбожээ. Д.Равжаа төдийгүй энэ үеийн уран зохиолыг шинэчлэгчдийн шүлэгт агуулгын эрс шинэчлэл хийгдсэн ч шүлгийн тогтолцоо нь огт өөрчлөгдсөнгүй. Өөрөөр хэлбэл дээрх жишээ шүлгүүдийн толгой үеэр, үгээр холбогдож, энэ холбоцоо дагаж мөрүүдийн үг, үеийн тоо харьцангуй жигдэрч ижил хэмнэл үүсгэсэн байна. Хөл холбоц нь харин эртний монгол шүлгийн нэгэн адил хос уянгыг өрсөн бүтэцтэй шүлгийн нэг, гуравдугаар мөр, хоёр, дөрөвдүгээр мөрүүд салаавчлан холбогдож уг шүлгээ нягтруулан нэгтгэж тогтолцоог нь тогтворжуулсан бол мөрүүдийг шууд ижилсүүлэн ар араас нь угсруулан өрсөн “Ичиг ичиг” шүлэгт хөлийг туушид нь жигд холбосон онцлогтой байна. Холбоцын энэ аргууд уугуул монгол шүлгийн үндсэн арга юм.

Тэгвэл өрнөдийн шүлэглэх арга маягаас тодорхой хэмжээгээр суралцсан XX зууны монгол шүлгийн холбоцыг энэ үеийн гол төлөөлөгчид болох Д.Нацагдорж, Б.Явуухулан нарын шүлгээр төлөөлүүлэн авч үзэж болно. Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлэгт,

*Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар
Монголын сайхан оронд жил жил дэлгэр
Энх улирал ханхлахад хүний сэтгэл тэнэгэр
Өвсний соёо ногоороход морь мал ханагар
Холхи нар ойртож хасын цас хайлахад
Хуучин дэлхий халагдаж хамаг юм шинэднэ
Хөхөрсөн мод цэцэглэж хүүхэд багачууд наадахад
Хөгийн хүн өөрийгөө залуу болсон шиг санана ...
Элдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд
Эрт эдүгээг бодогдуулан нуугдсан сэтгэлийг сэргээнэ
Өнөр сайхан төл баян хотыг чимэхэд
Өлгийтэй бяцхан хүүхэд эцэг эхээ баясгана* [Нацагдорж Д. 1996:133]

хэмээн шүлэглэхдээ тууш болоод зэрэгцсэн холбоцуудаар толгойг уран холбожээ. Тэгвэл Б.Явуухулан “Би хаана төрөө вэ?” шүлэгтээ,

*Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би
Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт
Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд*

Хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх төдий тэртээд
Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би
Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би
Цан хүүрэг савсаж үүлс ороох оргилд
Цасан ширхэг царцаж мөс болох халилд
Царгиа хүйтэн өвөл сарлагийн бух тошсон
Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би
Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би
Орог саарал зэрэглээ хавар сүүмэлзэх хөндийд
Орсон буурын шүд өвөл хангинах хоолойд
Үлэг гүрвэлийн мөрийг өдий хүртэл хадгалсан

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би ... [Явуухулан Б. 1985:387]
хэмээн тууш холбоцоор гүнзгий холбожээ. Дээрх шүлгүүдийн толгой холбоцыг чанд гүн холбосноор толгой холбогдсон мөрүүдийн өргөлтүүд жигдэрч, улмаар өргөлттэй өргөлтгүй үеийн тоо таарсан байна. Өргөлттэй, өргөлтгүй үеийн тоо таарч байгаа нь тухайн шүлгийн хэмнэл ижилсэж байгаа хэрэг бөгөөд угтаа бол монгол шүлэг үе-өргөлтийн тогтолцоотой шүлэг болохыг баталж байна. Монгол хүн өвөг дээдэс, аав ээж, ах захаа гүнээ хүндэтгэнэ. Өмнөх үеийнхээ захиас даалгавраар дараа үе нь замнадаг жамтай. Өмнөх үеийнхээ нөлөөнд орж тэдний үзэл бодол, сургаал номлолд дараа дараагийн үе нь захирагдаж амьдрах энэ жам зүй тэдний бүтээсэн шүлэг найргийнх нь зүй тогтолтой ч хамааралтай гэлтэй. Өөрөөр хэлбэл өмнөх үедээ дараа үе нь найрсан захирагдаж, тэдний нөлөө хамааралтай амьдрах энэ жам монгол шүлгийн хөл хийгээд дунд холбоц, мөр бүрийн үг, үеийн тоо хэмнэл таарах зүй тогтол зэрэг нь толгой холбоцоосоо улбаатай, түүний нөлөө хамаарлаар буй болдогт уламжилсан гэсэн үг. Энэ нь монгол шүлгийн хувьд толгой холбоц нь шүлгийн тогтолцоонд чухал нөлөөтэйг харуулж байгаа хэрэг. Энэ утгаараа монгол шүлгийн толгой холбоц онцгой ялгарч харагддаг байна. Монгол шүлгийн толгой холбоц илүү товойж харагдах энэ онцлогийг монгол шүлгийг судласан дотоод, гадаадын бараг бүх судлаачид анзаарч “Монгол шүлгийн гол шинж бол толгой холбоц” хэмээн бичсээр ирсэн байна.

Хүний хэл ярианы үүсэлтэй зэрэгцэж шахуу үүссэн гэж хэлж болох уриа дуудлагын үгс, хэл зүгшрүүлэх үгс тэргүүтэн, үгийн ид шидэнд итгэх эрт үед үүссэн дом шившлэгийн үгс, ертөнцийг үзэх үзэл бодлын илэрхийлэл болох зүйр цэцэн үгс, сэтгэлийн баяр хөөр, уйтгар гунигийг харуулах ардын дуу тэргүүтнээс эхлүүлээд хэдэн мянган мөр шүлэгтэй баатарлагийн туульс хийгээд эрт эдүгээгийн бичгийн уран зохиол дахь шүлгийн ихэнх нь тогтвортой толгой холбогдсон байгаа нь “толгой холбох ёс монгол шүлэгт тэргүүлэх үүрэгтэй”-г гэрчилнэ. “Монгол шүлгийн толгой холбох зарчим маш дээр үед үүссэн бөгөөд хэл сэтгэхүйн нарийн зүй тогтоолоор улмаар хувьсан хөгжиж ирсэн түүхтэй.” [Цэрэнсодном Д. 1977:88]

Монгол шүлгийн толгой холбоцыг хэлбэр байрлалын үүднээс нь авч үзвэл тууш холбоц тэргүүлэх үүрэгтэй байж, зэрэгцэх, салаавчлах, хаших холбоцууд дагалдах шинжтэй байна. Эдгээр түгээмэл холбоцуудаас гадна дотоод хийгээд гинжин зэрэг холбоцууд ч мэр сэр байна. Тухайлбал, шүлгийн эхний мөрийн сүүлийн үг, дараагийн мөрийн эхний үг болох угсран гинжлэх маягаар холбогдож холбоц үүсгэдэг онцлог монгол шүлэгт тодорхой хэмжээгээр байна. Жишээ нь,

Монголын модон хүрээ
Хүрээний хүчин начин
Начны найман галуу

Галууны ганц өндөг ... [Гаадамба Ш., Цэрэнсодном Д. 1978:93] зэрэг ийм төрлийн холбоц ихэвчлэн утга илэрхийлэхээс илүүтэй дүрслэл бүтээх бүхий хүүхдийн хэл яриаг сайжруулах маягийн тусгай зориулалттай шүлгүүдээс түлхүү ажиглагдаж байна. Энэ нь магадгүй монгол шүлгийн холбоцууд өнөөдрийнх шиг салж тодорхой болохын өмнөх үеийн нэгдмэл буюу холбоц үүсч байсан онцлогыг харуулж байх шиг байна. Гэхдээ ийм маягийн холбоцыг улам боловсронгуй болгож холбосон шүлэг орчин үед цөөнгүй байна. Жишээлбэл, Д.Нямаагийн “Аргалын уул” шүлэгт,

Саахалт хоёр айлын

Санаа нэг гэдэг шиг

Сайхан хоёр уулын

Салхи бас нийлнэ

Сайхан хоёр уулын

Салхи нийлэв гэхэд

Ботгон цагаан үүлний

Бороо бас нийлнэ

Ботгон цагаан үүлний

Бороо нийлэв гэхэд

Цэнхэр хоёр уулын

Цэцэг бас нийлнэ ... [Нямаа Д. 1998:191] хэмээн шүлэглэсэн байна. Энэ нь толгой холбоц, ерөөс ямар ч төрлийн холбоцыг үүсгэх боломж монгол шүлэгт түгээмэл байгаагийн баталгаа болно.

Монгол шүлгийн хөгжлийн явцад толгой холбох арга улам боловсронгуй болон төлөвшиж, тэр хэмжээгээр монгол шүлгийн тогтолцоо бат бөх тогтвортой болсон байна. Монгол шүлэгт шүлгийн толгой холбоцыг гийгүүлэгчээр эхлүүлж хийх, эгшгээр эхлүүлж хийх хоёр янз байх ч гийгүүлэгчээр эхлэсэн толгой холбоцтой шүлгийн утга гүн, эгшиглэнт шинж дагалдах шинжтэй, харин эгшгээр эхлэсэн толгой холбоцтой шүлгийн эгшиглэнт шинж гүн, утга дагалдах шинжтэй болдог онцлог ажиглагдаж байна. Энэ бол монгол шүлгийн толгой холбоц маш нарийн зүй тогтолтой зүйл болохыг баталж байгаа юм. Иймд хэн ч хараад энэ бол монгол шүлэг байна гэж таних гол онцлог бол шүлгийн толгой холбоц ажээ.

Холбоц үүсгэх авиа хэрхэн бүтэж, улмаар өгүүлэхүйн эрхтэнтэй зохицон найрч дараа дараагийн мөрүүд урган гарах суурь дэвсгэр болоход толгой холбоцын гол онцлог хадгалагдаж байдаг. Энэ нь монгол шүлгийн бүтцийн нэг гол онцлог нь толгой холбоц мөн болохыг баталгаажуулж байгаа хэрэг. Монгол хэл эгшиг зохицох зарчимтай тул шүлгийн толгойг холбохоор дараагийн үгс эхний үгэндээ дууны болоод утгын талаасаа захирагдаж ижилсэх тул толгой холбоц чухал зүйл юм. Өөрөөр хэлбэл холбоцууд нь туурвигч үндэстнийхээ соёл сэтгэлгээ, аж амьдралтай нарийн холбоотой зүйл аж. Холбоц үүсгэх авиа өөртэйгөө хамгийн ойр хэлэгдэх, сонсогдох авиатай нэгдэх тул холбоц үүсгэх авианд өөрөө өөртөө хамгийн ойр байх тул тууш холбоц маш түгээмэл байдаг байна. Харин тууш холбоц өөр холбоц руу шилжихдээ мөн л өөртэйгөө хамгийн ойр дуудлагатай утгын хувьд ижилсэн ундрах авиа руу шилждэг байна.

Ертөнцийн бүх зүйл зүй тогтолтой. Зүй тогтол нь орших үндэс нь болно. Монгол шүлэг хэл, сэтгэлгээний нарийн чухал зүйлүүдийг тээж оршино. Тиймд монгол шүлгийн зүй тогтлоос монгол хэл, соёл сэтгэлгээний зарим зүй тогтлыг ч харж болмоор байна. Жишээ нь, монгол хэлний бүх авиа бүгд бие биенээсээ урган, бие биенийхээ шүтэлцээнд оршин байгаа нь мэдээж хэрэг. Тэд хэлэгдэх сонсогдох үүднээсээ (бүтэх газраараа) бие биенээсээ хэрхэн урган гарч, бие биеэнтэйгээ хэрхэн шүтэн барилдлагатай байгааг олж болмоор. Шүлэг бол яруу хэлэгдэх, яруу сонсогдох урлаг. Тиймд шүлгээс, тэр дундаа шүлгийн холбоцуудаас

монгол хэлний авиа үсгийн бие биенээсээ урган гарч, шүтэн барилдаж орших зүй тогтлыг олж харж, тогтоож болмоор байна. Өөрөөр хэлбэл ямар авиа үсэг, ямар авиа үсгээсээ ундарч, тэр утгаараа хамгийн ойр дуудагдаж, хамт шүтэн барилдаж оршиж байгааг тогтоож болно. Ингэж авиа үсгийн байрлалыг зөв тогтоож чадвал анх бичиг үсэг сурч байгаа хүүхэд, монгол хэл сурч байгаа гадаад хүнд монгол хэлний үсгийг ямар дараалалтай зааж болох нь тодорно. Сонгож авсан шүлгийн толгой холбоцуудаас ямар авиа, ямар авиатай хамгийн олон удаа найрч холбоцуудыг үүсгэж байгааг ажиглаж үзвэл, нэгдүгээрт, авиа ижил авиатайгаа хамгийн олон удаа найрч холбоц үүсгэж байгаа нь тодорхой байна. Энэ бол мэдээж хэрэг. Учир нь авиа дуудагдах дуудлагаараа өөрөө өөртэйгөө шууд давхцана. Тиймд монгол шүлэгт холбоц чухал үүрэгтэй нь харагдаж байна. Хоёрдугаарт, эгшиг авиа бусад эгшиг авиатайгаа илүү их холбогдож байна. Энэ нь эгшиг авианаас эгшиг авиа урган холбоц үүсгэдгийг харуулж байна. Эгшиг авианы дараалал нь “а, э, о, ө, у, ү, и”. Нэгдүгээрт өгүүлсний дагуу авиа авиатайгаа найрах зарчмаар богино эгшиг авианаас урт эгшиг авиа, улмаар хос эгшиг авиа үүсэх нь мэдээж хэрэг. Байрлал нь богино эгшигийн үүсэх дараалал давтагдана. Монгол хэлэнд хос эгшиг хожим үүссэн гэдгийг мартах аргагүй. Үндсэн эгшгүүдийн дараа “я, е, ё, ю, ...” гэсэн туслах эгшгүүд үүссэн зүй тогтол байна. Гуравдугаарт, монгол шүлгийн толгой холбоцоос ямар гийгүүлэгч ямар гийгүүлэгчтэйгээ илүү ижилсэж тэр хэмжээгээрээ холбоц үүсгэж байгааг ажиглавал уруулын, хэлний гийлүүлэгчүүд гэсэн дэс дараалал харагдаж байна. Өөрөөр хэлбэл эгшиг авиануудын дараагаар хоёр уруур хамжиж бүтээх “б, м, в, (п)” гэсэн уруулын гийгүүлэгчүүд, дараа нь хэлний өмнө тал буюу үзүүр идэвхтэй оролцож дээд шүд ба буйланд хамжиж бүтэх “д, т, ц, ч, з, ж, н, с, ш, л, р” гэсэн хэлний үзүүрийн гийгүүлэгчүүд, дараа нь хэлний дунд хэсэг идэвхтэй оролцож тагнайд ойртож бүтэх “ж” гэсэн хэлний дундуурх гийгүүлэгч, хамгийн сүүлд хэлний угийн хэсэг дээш өргөгдөж бүтэх “(хэлний гүн бус угийн г, х), (хэлний гүн угийн г, х) нг, (к)” гэсэн гийгүүлэгчүүд бүтэж байна.

Хэл үүсч, хөгжсөн замыг хүүхдийн хэл туулдаг гэж хэлний шинжээчид үздэг аж. Тиймд хүүхдийн хэлийг судласан судалгааны бүтээлүүд, ерөөс өөрсдийнхөө хүүхдүүдийн хэлийг ажиглахаар хүүхэд эхлээд эгшиг авиа түлхүү гаргадаг байна. Тэгээд өөрт хамгийн ойр байгаа хүнийг хэлж эхэлнэ. Энэ нь аав, ааб, ам, улмаар ээж, ах, эгч, өвөө, эмээ гэх мэт. Энэ нь хүн угаасаа хэлийг бий болгохдоо өөрт хамгийн ойр чухал хүмүүсээ дуудаж эхлэх тул дээрх хамаарал бүхий хүмүүсийг дуудахдаа дандаа эгшгээр эхлүүлэн уруул, хэлний үзүүрийн гийгүүлэгчтэй хамжуулан дууддаг байна. Дараа нь хүүхэд ямар нэг үйлдэл илэрхийлсэн үг хэлдэг байна. Жишээ нь уу, ид, яв, уна, уйл гэх мэт. Энэ нь мөн л хүн ямар нэг үйлдлийг эхэлж хэлэхдээ эгшиг түлхүү ашигласныг батална. Үүнийг монгол шүлгийн холбоц бүр бат нотлож өгч байна.

Монгол шүлгийн холбоцууд тэр дундаа толгой холбоц бол шүлгийг жигд сайхан харагдуулах гадаад хэлбэрийн төдий зүйл бус бадгийг бүтээж байгаа мөрүүдийн үе, үгийн хэлбэлзлэлийг тааруулан жигдэлдэг, уншихад өгүүлэхүйн эрхтнүүдийн зүй тогтлын онцлогийг илэрхийлэх, сонсоход сонсогдох яруу тунгалаг шинжийг үүсгэдэг шүлгийн тогтолцоо, дотоод мөн чанарын чухал үзэгдэл ажээ.

ДҮГНЭЛТ

- Толгой холбох ёс монгол шүлэгт тэргүүлэх үүрэгтэй аж. Шүлэг туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний цөм хэв загварын илэрхийлэл болж бүтдэг. Монгол хүний сэтгэхүйд аливаа зүйлийн эхлэлийг эрхэмлэн чухалчилж үзэх үзэл шингэсэн байх тул шүлгийн тэргүүн мөрүүдэд хүчдэлт өргөлт өгөгдөж, тэрхүү өргөлттэй уялдаатайгаар толгой холбоц үүсгэдэг байна. Энэ утгаараа толгой холбох арга бол монгол шүлгийн уугуул шинжийг илэрхийлж оршдог зүйл юм.

- Монгол шүлгийн толгой холбоц өнгөн талаасаа шүлгийн мөрүүдийн эхлэлийг хэлэгдэх үүднээс нь ижилсүүлэн холбож яруу сайхан сонсогдох шинжийг баяжуулдаг уран сайхны өвөрмөц арга болдог бол дотоод шинжээрээ шүлгийн мөрүүдийг айзам хэмнэлийн үүднээс нь ижилсүүлэн хооронд нь тэгшитгэх үүргээрээ шүлгийн тогтолцооны чухал зүйл ажээ.
- Монгол шүлгийн хөгжлийн явцад толгой холбох арга улам боловсронгуй болон төлөвшиж, тэр хэмжээгээр монгол шүлгийн тогтолцоо бат бөх тогтвортой болсоор иржээ. Монгол шүлэгт шүлгийн толгой холбоцыг гийгүүлэгчээр эхлүүлж хийх, эгшгээр эхлүүлж хийх хоёр янз байх ч гийгүүлэгчээр эхлэсэн толгой холбоцтой шүлгийн утга гүн, эгшиглэнт шинж дагалдах шинжтэй, харин эгшгээр эхлэсэн толгой холбоцтой шүлгийн эгшиглэнт шинж гүн, утга дагалдах шинжтэй болдог онцлог ажиглагдаж байна. Энэ бол монгол шүлгийн толгой холбоц маш нарийн зүй тогтолтой зүйл болохыг баталж байгаа хэрэг. Иймд хэн ч хараад энэ бол монгол шүлэг байна гэж таних гол онцлог бол шүлгийн толгой холбоц ажээ.
- Монгол хүн өвөг дээдэс, аав ээж, ах захаа гүнээ хүндэтгэнэ. Өмнөх үеийнхээ захиас даалгавраар дараа үе нь замнадаг жамтай. Ахмадынхаа үзэл бодол, сургаал номлолд дараагийн үе нь захирагдаж амьдрах энэ жам зүй бүтээсэн шүлэг найрагт нь ч уламжлагдаж үлддэг байна. Өөрөөр хэлбэл өмнөх үедээ дараа үе нь найрсан захирагдаж амьдрах энэ жам монгол шүлгийн хөл хийгээд дунд холбоц, мөр бүрийн үг, үеийн тоо ижилсэж айзам хэмнэл таарах зүй тогтол зэрэг нь толгой холбоцоосоо улбаатай, түүний нөлөө хамаарлаар буй болдогт уламжилсан гэсэн үг. Энэ нь монгол шүлгийн хувьд толгой холбоц нь шүлгийн тогтолцоонд чухал нөлөөтэйг харуулж байна. Монгол шүлэгт толгой холбосноор тэдгээр мөрүүдийн үгийн өргөлтүүд жигдэрч, улмаар өргөлттэй өргөлтгүй үеийн тоо таардаг байна. Өргөлттэй, өргөлтгүй үеийн тоо таарч байгаа нь тухайн шүлгийн хэмнэл ижилсэж байгаа хэрэг бөгөөд утгаа бол монгол шүлэг үе-өргөлтийн тогтолцоотой шүлэг болохыг баталж байна.

SUMMARY

Keywords: *Rhyme, Alliteration, Regularity, Mongolian verse, Syllable, Accent*

A rhyme is one of the many factors that constitute a poetical versification. The rhyme is in the shape of a verse in perfecting the form of poetry, but it connects with the language and mind of a nation that is essentially homogeneous. The Alliteration of Mongolia verse is based on the ideas of Mongolian people that prefer the beginning of everything and the poet expresses the indigenous way of thinking of the nation, from the historical evolution of the Mongolian verse, it is predominant to connect the alliteration at any time. In the course of development of Mongolian verse, the alliteration has become more improved and matured, the link between Mongolian verse and the development of the verse has become more refined and mature, and at the same time, the Mongolian verse system has been steadily stable.

The beginning of a linear verse is being with same, identical analogous, and synonym pronunciation and meaning or being antonym pronunciation and meaning, and the alliteration is created by word and syllable which holds special meaning in the verse. Therefore, it is required to be careful to translate the verse and to express its meaning. As the beginning of the line verse connected each other having set in special legitimacy, the beginning of verse assimilated to each other through the lines and created the same rhythms. The Alliteration in Mongolian verse is created by two different ways that starts by consonant or vowel. The poetry with alliteration started by consonant is being with deep meaning but the with alliteration started by vowel is characterized

more musical and dulcet. So, it certifies that more alliteration of Mongolian verse holds very special legitimacy. Thus, the alliteration is mean character which can express of Mongolian verse.

НОМ ЗҮЙ

- Буяннэмэх С. 1935. *Утга зохиолын үүд*. Гар бичмэл. Улсын Нийтийн Номын Сангийн гар бичмэлийн хөмрөгт буй. Улаанбаатар.
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д. 1978. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Уб.,
- Галбаатар Д. 2012. *Уран зохиол: Онол, түүх, шүүмж. Нэвтэрхий толь*. Уб.,
- Гүначуг В. 1959. *Гүлиранс, Данзанванжил, Хишигбат: Түүвэр*. Хөххот.
- Дамдинсүрэн Ц. 1938. *Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай* ("Олег сэцэний дуулал"-ын орчуулгын тайлбар), Шинэ толь, №2 (14), Уб.,
- Жамбалсүрэн Н. 1966. *Монгол шүлэг*. Утга зохиол, урлаг сонин. №8. Уб.,
- Жирмунский В. 1923. *Рифма, её история и теория*. Петроград.
- Жирмунский В. 1975. *Теория стиха*. Лг.
- Инжаннаши В. 1959. *Хөх судар*. Тэргүүн дэвтэр. Хөххот.
- Квятковский А. 1983. *Поэтический словарь*. М.
- Лувсанданзан. 2011. *Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai*. Уб.
- Morner, Kathleen. 1998. *NTC's Dictionary of Literary Terms*. New York.
- Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даягаас бармидын аймаг оршив. Бармидын хорин гурав /23 дугаар тал/, Улсын Нийтийн Номын Сангийн гар бичмэлийн хөмрөг.
- Нацагдорж Д. 1996. *Бүрэн түүвэр*. Уб.
- Нямаа Д. 1998. *Их газрын чулуу*. Монголын уран зохиолын дээж-ЛII. Уб.
- Позднеев А. 1880. *Образцы народной литературы монгольских племен*. Народные песни монголов. СПб.
- Поппе Н. 1937. *Халха-монгольский героический эпос*. Изд. АН.СССР. М-Лг.
- Поуха П. 1968. *Монголчуудын нууц товчооны зарим нэг шинэ судалгаа*. *Studia Mongolica*. T-VI, fasc. 23, x.19-32. Уб.
- Равжаа Д. 1992. *Яруу найргийн цоморлиг*. Уб.
- Rachewiltz, Igor De 1972. *The Secret History of the Mongols*. Bloomington.
- Ринчен Б. 1970. *Монгол шүлгийн учир*. *Studia linguae et litterarum*. T-VIII, fasc 2, x.5-50. Уб.
- Түдэв Л. 2002. *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган-VI. Уб.
- Цэдэв Д. 1974. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб.
- Цэнд Д. 1979. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд. Уб., x.130-180.
- Цэрэнсодном Д. 1977. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб.,
- Цэрэнсодном Д. 2012. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Уб.
- Wesling, Donald 1980. *The chances of rhyme*. University of California Press.
- Явуухулан Б. 1985. *Түүвэр зохиол*. Уб.